



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/110

Булган сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын хөгжлийн шинэчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар (РД:9013431)-ын Булган сум 5 дугаар баг Анхдагчдын өргөн чөлөө 1 дүгээр гудамж 132 тоотод байршилтай 6308003490 нэгж талбар бүхий албан контор, ажилчдын байрны зориулалтаар эзэмшиж буй 1607 м² газар, “Дэлгэр тэрэм” ХХК (РД:3188949)-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 18 дугаар гудамж 1806 тоотод байршилтай 6308003426 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 1525 м² газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг тус тус 15 жилээр сунгасугай.

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, “Дэлгэр тэрэм” ХХК-ийн 3.Сумьяа нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, “Дэлгэр тэрэм” ХХК нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010052